

МОНГОЛ УНШЛАГЫН СУДЛАЛЫН ТУХАЙД

Д.Ганбаатар - МУИС. НШУС.Шашин судлалын тэнхим, докторант

Түлхүүр үг: Чойжи-Одсэр, Нэйж тойн, Мэргэн гэгээн, бурхан шашин, шад тэгшлэлт, ая дан, хурлын уншлага, судар, аялгуу хэмнэл, эх монгол хэл, уламжлал, шашины дэлгэрэлт

Товч агуулга: Эл өгүүлэлд монголчуудын уламжлалт шашин болсон бурханы шашны уншлага ном хэдий үеэс эхлэн хэрхэн монгол хэлнээ хөрвүүлэгдэх болсон хийгээд монголчууд өөрийн хэл дээр тогтсон уншлагатай болсон тухай, тэрчлэн тэдгээр монгол уншлагын талаарх судалгаануудын талаар өгүүлэх болно. Тэрчлэн монгол уншлагын ач холбогдол, учир зүйн талаар цухас авч үзсэн болно.

Бурхан багшийг нирваан дүр үзүүлснээс хойш 180 жилийн дараа буюу Хятад, Төвдөөс өмнө Хүннү улсын үед Бурханы шашин Монгол орноо дэлгэрч түүнээс хойш 2000 шахам жилийн турш монголчууд Бурхан багшийн сургаалыг санскрит, төвд, уйгар зэрэг хэлээр дамжуулан сурч, судлаж байсны сацуу өөрсдөө бүтээж туурвин, улмаар эх хэлээрээ урьж номлосоор ирсэн нь монголын түүхэн сурвалж бичгүүдэд тэмдэглэгдэн үлдсэн байна¹

*Шашины дунд дэлгэрэлтийн үед Чойжи-Одсэр тэргүүтэн хоёр хэлний дуун хөрвүүлэгч нар монгол хэлээр хурал номоо хурж уншихад тохируулан, бурханы шашины хамаг номыг эх хэлнээ орчуулж байжээ.*²

Монголчуудын бурханы шашны номыг төрөлх хэлээрээ уншиж байсан улбаа шашны хожуу дэлгэрэлтийн үед Нэйж тойн хутагт (1557-1653), Зая бандида Намхайжамц (1559-1662), Өндөр гэгээн Занабазар (1635-1723), Мэргэн гэгээн Лувсандамбийжанцан (1717-1766), Цахар гэвш Лувсанчүлтэм (1740-1810) зэрэг эрдэмт лам нарын хичээл зүтгэлээр хөгжин дэлгэрчээ.

Ийнхүү төрөлх хэлээрээ хурал номоо хурж, өөрсдөө бие даан уншлага заллага хийж, гүн ухааны судар шастир зохиох болсон нь бурханы шашныг монгол соёлын хөрсөнд шингээж өгсөн чухал үйл болжээ. Эдүгээ манай улс тусгаар тогтносон улсын хувьд өөрийн үндэсний хэлээр шашин номоо дэлгэрүүлж чадахгүй харь хэл уламжлалаар шашны үйлээ зонхилон эрхлэн явуулж байгаа нь хэр зөв эсэхийг шүүн хэлэлцэх цаг эрхбиш болсон гэж үзэх учир бий юм. Уламжлал болсон гэлтгүй төвд хэлээр шашны номлол сургаалыг хөтлөн явуулж байгаа нь ч өөр шашин лугаа нөхөрлөх бас нэг үндэс болж байгааг анхааран авууштай юм.

Хүний эрх, эрх чөлөө, улмаар шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай ярих болж, хүний өөрийн олон шашин нэгэн зэрэг байр суурь булаалдах болсон өнөөгийн өдөр аль нь илүү ойлгомжтой байна вэ? гэдэг нь тэдгээрийг шүтэх, эс шүтэх хэмжүүрийн нэг болж байна гэж үзэж болно. Сүүлийн жилүүдэд манай улсад өргөжин тэлж буй олон шашны үйл ажиллагаанаас харахад тухайн шашныхаа номлол сургаалыг монгол хэлнээ хөрвүүлж, зураг хөргөөр чимж, насанд хүрсэн хүрээгүй хэн бүхэнд ойлгомжтой болгон

¹ Сүмбэ хамба Ишбалжир (1704-1788) "Энэтхэг, Төвд, Монгол орнуудад дээдийн ном ямар мэт дэлгэрсэн галбарваарсан мод" АХХ, 1991 он, Цахар гэвш Лувсанчүлтэм (1740-1810) "Эрдэнэ дошийн хөх дэвтэр", Зава Дамдин гавж "Алтан дэвтэр" зэрэг болно.

² Louis Ligeti. Gatalogue du Kanjur mongol impire. Budapest. 1942-1944. P.333.

хялбаршуулан тарааж байна. Энэ нь манайд гадаадын шашин дэлгэрэх таатай хөрс суурь болж байгаагийн зэрэгцээ эргээд уламжлалт шашнаас татгалзах, түүнд эргэлзэх, улмаар өөр шашинд эргэлт буцалтгүй татагдах, уламжлалт шашнаар маань дамжсан монголын буддын соёлыг бүдгэрэхэд хүргэж байгаа нь бас анзаарагдаж байна. Эдүгээ монголд бурханы шашны зэрэгцээгээр шинэ тутам дэлгэрч буй шашнууд өөрийн сургаал номлолоо монгол хэлээр заан сурталчилж байгаа нь залуучуудын оюун санааг эзэмдэж сонирхлыг нь ихээхэн татаж байна.

Манай орноо удаа дараа дэлгэрсэн Бурханы шашин нь монгол хүний сэтгэлгээ, соёлын хөрс сууринд нь баттай шингэж үеэс үед уламжлагдан ирсэн бөгөөд бидний ахуй амьдрал, зан суртахуунд гүнзгий ул мөрөө үлдээсэн нь судалгаанаас харагддаг. 2000 жилийн тэртээгээс дэлгэрсэн монголын уламжлалт шашин болох Бурханы шашны номлол сургаалыг эх хэлээрээ дэлгэрүүлэх нь лам, хар хэнд ч бурханы шашны номыг уншиж ухаарах таатай боломжийг өргөнөөр олгох нь дамжиггүй.

Мөн тэрчлэн буддизмд агуулагдаж байгаа мэдлэг ухааны баялаг уламжлалаас суралцах, танин мэдэх, орчин үеийн шинжлэх ухаантай хослуулан хөгжүүлэхэд монгол уншлага, орчуулга, тайлбар сэлт чухал ач холбогдолтой гэж үзнэ.

Дундад зууны үед Монгол орноо бурханы шашин дан төвд хэлээр дэлгэрснээр бурханы шашны гүн гүнзгий утга агуулгыг төвд хэлийг сайтар эзэмшсэн цөөн тооны мэргэд л ойлгодог, харин нийт сүсэгтнүүдийн хувьд мухар сүсгийн харанхуй ертөнц болон хувирч байсан нь түүхээс тодорхойхарагддаг. Харин Өвөрмонголд эх хэлээрээ шашин ном дэлгэрүүлж, улмаар Монголоос илүү амжилтанд хүрч, эрдэм номтон олноор төрөн гарч байсан тухай улстөрч Баабар (Б.Батбаяр) "...XV-XVII зууны нүүдэлчдийн дунд дэлгэрсэн Бурханы шашин нь дээд лам нарын явцуу хүрээнд л жинхэнэ утгаараа ойлгогддог, харин ард түмэнд тусахдаа мухар сүсэг болж тусч байсан нь шашны сургалт нь зөвхөн төвд хэл дээр явагддагаас болж байсан" тухай дурьдаад цааш нь "...харин Өвөрмонголд арай дээр байв. Тэнд сүм хийдүүд Монгол хэлээр ном хурах, Монгол соёлоо хадгалах байдал хавьгүй илүүтэй байсан учир чухам л XVII-XX зууны монголын соён гийгүүлэгчид, бичгийн их хүмүүс, эрдэмтэн түүхчид чухам л Өвөрмонголчууд байсан юм"¹ гэж анзаарууштай дүгнэлт хийсэн байдаг юм.

Монголчууд төрөлх хэл, бичгээрээ бурханы шашны уншлага явуулдаг байсан нь өдгөө уламжлагдан ирсэн бөгөөд тухайлж Урадын Мэргэн гэгээний хийдийг хэлж болох юм. Энэ хийд 300 жил тасралтгүй дан монгол хэлээр уншлагаа уншсаар ирсэн байна. Одоо тус уламжлалаар үйл ажиллагаагаа явуулдаг монгол уншлагат "Буян арвижихуй" хийд үйл ажиллагаагаа тогтмол явуулж байна. Энэ бол бид монгол хэлээрээ шашныхаа аливаа үйл ажиллагааг явуулж болохын нэгэн жишээ мөн.

Түүнчлэн бурханы шашны мэдлэг ухааны чиглэлүүдээр туурвисан сод бүтээлүүдийн гол цоморлиг Ганжуур хийгээд Данжуур их хөлгөн судрууд монгол хэлээр хадгалагдаж буй нь бахархалтай байна. Монгол хэлээр зохиол бүтээлээ туурвин үлдээсэн эрдэмт лам нар ч бас бишгүй олон буйг дурьдах учиртай.

Тийм ч учраас өдгөө мартагдах шахсан монгол уншлагыг судлах шаардлага илүүтэй тулгарч байгааг харгалзан эртний уламжлалт монгол уншлагаа дахин сэргээх, сүсэгтэн олон, сонирхон судлагчдад тэрхүү монгол уншлагын журмаас товч танилцуулах энэ ажлыг чухалчлах хэрэгтэй байна. Түүний зэрэгцээ монгол уншлагыг эрин цагийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн уламжлал шинэчлэлийн зохистой харьцааг олж хөгжүүлэх нь зүйтэй юм.

¹ Б.Батбаяр "XX зууны Монгол" нүүдэл суудал, УБ 1996, 173

Монгол уншлагын талаар хийгдсэн дорвитой судалгаа гэвэл, академич Д.Цэрэнсодном монгол уншлагын "Номун гэрэл" төв байгуулан, монгол уншлагын түүхэн уламжлалын талаар судлан, "Бурханы номыг монголоор урихуй уламжлал хийгээд урагын Мэргэн гэгээний шинэчлэл" ¹ нэртэй үгүүлэл бичсэн. Энэхүү бүтээл нь Мэргэн гэгээн судлалын цуврал ботид нийтлэгдсэн бөгөөд тухайн үедээ олны сонирхолыг ихээхэн татаж чадсан билээ. Тэрчлэн "ХИУ зууны үеийн яруу найрагч Чойжи-Одсэр", "Бурханы шашны уран зохиол", Чойжи-Одсэрийн Бурханы 12 зохионгуйг эмхэтгэн гаргаж, монгол Одсэр бандида, хэлмэрч Шаравсэнгэ тэргүүтэн гүүш нар энэтхэг, төвд зэрэг хэлнээс Бурханы шашины өдий төдий ном зохиолыг орчуулж байсны нэг зорилго нь хурал номын уншлагыг монгол хэлээр урих болсонтой холбоотой болвуу" ² гэсэн нь тухайн үед монголд сүм хийдүүд монгол хэлээрээ уншлагаа уншдаг байсныг ийнхүү дүгнэж хэлсэн байна. Академич Д.Цэрэнсодном 1970-аад оноос хойш мэргэн гэгээн Лувсандамбийжанцангийн талаар судлан эрдэм шинжилгээний өгүүлэл нэлээдийг бичиж нийтлүүлжээ.

Тэрбээр монгол уншлагын хөгжилд XIV Далай лам Данзанжамцын зарлиг айлдварыг авсныг тэмдэглүүштэй. 1995 онд "Чингис хаан" зочид буудалд Далай лам "Бурханы шашин, XXI зууны соёл иргэншил" сэдэвт лекц унших үед академич Д.Цэрэнсодном монгол уншлагын соронзон бичлэг тавьж сонордуулаад, Монгол улсын сүм хийдүүд шашны хурал номыг төрөлх хэлээрээ явуулахыг та хэрхэн үзэж байна вэ? гэж асуухад Далай ламтан бээр "...Бид уншлага номоо Энэтхэгээс авахдаа өөрийн хэлээр болгосон. Төвд хүний хувьд бид бурханы номыг эх хэлээрээ уншиж байгаа явдал бол бахархалтай зүйл. Бурханы номыг монгол хэлээрээ унших нь өөрийн ард түмэндээ тустай сайн зүйл. Гэхдээ сайтар хянан орчуулах хэрэгтэй. ..." гэж айлдсан нь буй.

Монгол улсын төрийн шагналт, гавьяат багш, профессор Ш.Чоймаа монгол уншлагын талаар сүүлийн үед нэлээд судалгаа хийгээд байна. 1998 онд болсон "Төр сүм хийдийн харилцаа-орчин үе" сэдэвт хуралд "Бурханы номыг монголоор хурах уламжлал шинэчлэл" илтгэл тавьж, уг илтгэлдээ монголд урьд цагт өөрийн төрөлх хэлээр хурал номоо хурж байсан түүхэн уламжлалын талаар баримт сөхөн үгүүлээд орчин үед бурханы номыг монголоороо уншихад юуг анхаарвал зохих вэ? гэдэг талаар чухал санал дэвшүүлжээ. Тэрбээр "...өнөө цаг үед лам хуврага нар эх монгол бичгээ шамдан сурах нь чухал, лам хуврагууд сахил санваараа сахин, буян үйлдэн, төвд номыг унших төдийгөөр хязгаарлалгүй сүсэгтэн олны сав саванд таацуулан утга уянга төгс сонгодог бичгийн хэлний яруу сайхан эх хэлээрээ ном тавьж байвал нэн сайн хийгээд аялгуу сайхан монгол хэл минь хайран яйран болж буй өнөө үед сонгодог бичгийн хэлний яруу тансаг үг хэллэгээс олны хүртээл болгоход Бурханы номын монгол уншлага тун их ач тустай" ³ хэмээсэн байна.

Мөн монголын нэрт эрдэмтэн доктор Л.Хүрэлбаатар "Монгол орчуулгын товчоон" хэмээх бүтээлдээ шашны дунд дэлгэрэлтийн үеийн буюу Чойжи-Одсэр бандида, Шаравсэнгэ нарын бурханы номыг монгол хэлнээ уншлагын хэлбэрт дөхүүлэн орчуулсан болохыг шад бүрийн үеийн тоо хэм хэмнэлийг нарийн тодорхой задлан шинжилж, монголоор орчуулагдсан бүтээлүүдийг нягт судалж баримтаар нотлохын зэрэгцээ, Зая Бандида намхайжамц (1599-1662), Дай гүүш Агваандампил (1700-1780), Цахар гэвш

¹ Мэргэн гэгээн судлалын өгүүлэлүүд. ҮХҮ., 1997. 251-263-р тал

² Д.Цэрэнсодном. "ХИУ сôóí ù çàëëí үдôóí àëôââ" ×1 éæë-Одсэр" УБ., 1969., 73 дахь тал

³ "Төр сүм хийдийн харилцаа-орчин үе" Онол практикийн бага хурал. УБ., 1998

Лувсанцүлтэм (1740-1810) нарын орчуулгыг төвд эх болон, үгчилсэн орчуулга зэрэгтэй нь харьцуулан судалсан нь монгол уншлагын судлалд нэгэн чухал судалгаа болж байна.¹

Өвөр Монголын багшийн их сургуулийн профессор Ү.Наранбат бол монгол уншлагыг хөгжүүлсэн Мэргэн гэгээний зохиол бүтээлийг эрдэм шинжилгээний үүднээс анх судалж шинжилсэн эрдэмтэн² юм. Тэрбээр 1984 оноос хойш эрчимтэй судалж “Монгол үндэстний их бичгийн хүн Мэргэн гэгээний тухай”, “Урад мэргэн гэгээний түүхийн зохиол ‘Алтан товч’” зэрэг түүний намтар түүх болон зохиол бүтээлийг нь судлаж, “Алтан товч” хэмээх түүхийн зохиолыг нь голчилсон байдаг. Мэргэн гэгээний зохиосон Монгол хэл сурах бичиг, Мэргэн гэгээн ба Ишданзанваанжилын зохиолын хэлний намба холбогдол, Мэргэн гэгээний бум зарлигт бичсэн удиртгал зэрэг бүтээлүүдийг гаргаж яруу найраг, хэл зохиолын талаас нь судалжээ. 1986 онд Ү.Наранбат удиртгал бичиж Галлуу, Жарантай нар эмхэтгэн хэвлүүлсэн “Мэргэн гэгээн Лувсандамбийжанцаны бум зарлиг хэмээгдэх оршив” гарчигтай нийт 882 хуудас бүхий том хэмжээний бүтээл гаргасан бөгөөд уул эмхтгэлд шүлэг, дуу, сургаал шүлэг, ерөөл магтаал, сан тахилга, наминчлал, даллага, хариулга, залбирал даатгал зэрэг 181 эхтэй их бага зохиолуудыг багтаан оруулсан байдаг. Нэг үгээр хэлбэл энд монгол уншлагын эх сурвалжуудыг дэлгэн харуулсанаараа уг бүтээл онцлогтой болсон юм. Мэргэн гэгээний зохиол бүтээлийн талаар Ч.Далай, Н.Сайшаалт, Ц.Энх, Э.Хурцбилэг, Б.Насан, Батсайхан нарын судлаачид ч багагүй зүйл хийсэн байна.

Академич Ц.Дамдинсүрэн “Эрдэнийн сан субашид”-ийг эмхэтгэн гаргаж Мэргэн гэгээний “Субашид”-ийн орчуулгыг Цахар гэвш Лувсанцүлтэм, Тойн Сономгара нарын орчуулга лугаа харьцуулан судалснаас гадна “Монголын уран зохиолын дээж зуун билэг” хэмээх бүтээлдээ Мэргэн гэгээний “Сайн үгт эрдэнийн сан” нэрт шастирийг эмхэтгэн оруулахдаа түүний намтар түүх тэргүүтнийг тайлбар сэлттэй хэвлүүлжээ. Тэрбээр, 50-аад оны тэртээ “Олег сэцний орчуулгын тайлбар” гэсэн үгүүлэлдээ “...Бас шашны мөргөлийн уншлага зэргийн шүлгийг хянавал тусгай журамтай, төвдийн шүлгийг дуурайсан төлөвтэй”³ гэсэн дүгнэлт хийсэн байдаг. Энэ бол академич бээр монгол уншлагыг төвд уншлагатай харьцуулж судалж байсны жишээ мөн.

Оросын болоод өрнө дахины эрдэмтэн судлаачид Мэргэн гэгээн судлалд үнэтэй хувь нэмэр оруулсаар иржээ. Үүнд:

А. М. Позднеев бээр 1900 онд хэвлүүлсэн “Монгол уран зохиолын дээж бичиг” хэмээх номондоо Мэргэн гэгээний зохиосон “Алтан товч”-ийн талаар судалсан төдийгүй зохиогчийн үзэл санаанд дүгнэлт хийн, улмаар гарал үүслийн талаар зохих шинэчлэл хийсэн нь Мэргэн гэгээнийг судалсан анхны судалгааны бүтээлд зүй ёсоор ордог. Мөн “...сэцэн хан аймгийн Тогтохтөрийн хошууны хурал номыг монголоор унших лугаа төвд хэлнээс монгол хэлнээ хөрвүүлж, Бээжинд барласан Жанц хутагтын сүмбүмийг уншина”⁴ хэмээн Позднеев абугай монгол уншлагын түүхийн талаарх бодитой баримтыг бичиж үлдээсэн нь ихээхэн сонирхолтой юм. Эндээс үзвэл ямартай ч То вангийн хошуунд монгол уншлага чамгүй сайн дэлгэрч байсныг харуулж байна.

Мөн эрдэмтэн Н.Поппе “Турфаны олдвор дахь нэгэн монгол шүлэг” үгүүлэлдээ “...Чойжи-Одсэрийн “Бодичария аватара”-ийн орчуулга толгой холбох зарчмыг алдагдуулсан”⁵ гэж тэмдэглэсэн нь буй. Энэ мэт судлаачдын гярхай ажиглалт нь монгол

¹ Л.Хүрэлбаатар “Монгол орчуулгын товчоон”, УБ.1995

² Ү.Наранбат Б.Мөнх “Мэргэн гэгээн судлалын өгүүлэлүүд”, ӨМСХХ. 1997

³ Ц.Дамдинсүрэн “Олег сэцний орчуулгын тайлбар” Монгол хэл бичгийн тухай, 1957.27-р тал

⁴ А.М.Позднеев “Очерки быта Буддийских монастырей и Буддийского духовенства в Монголии в связи с отношениями сего последнего к народу”. Улан-Удэ, 2000, 306-р тал

⁵ N.Poppe, Ein monolisches Gedicht aus den Turfan Funden. vol.5., 1960.294.

уншлагатай холбогдол бүхий анхаарууштай чухал санаа гаргаж буй бөгөөд нөгөө талаар монгол уншлагыг ихээхэн сонирхож байсны илрэл болно.

Буриадын нэрт эрдэмтэн П.Б.Балданжапов 1970 онд Мэргэн гэгээний "Алтан товч"-ийн гар бичмэлийг сийрүүлэн буулгаж орос орчуулгын хамт тайлбар хийн "Алтан товчи - Монгольская летопись" хэмээх ном хэвлүүлсэн нь нэн чухал судалгааны бүтээл болсон юм¹.

Мэргэн гэгээний дэлгэрүүлсэн монгол ном, зохиол бүтээлийн талаар өргөн цар хүрээтэй, гүнзгий судалсан хүн бол Герман улсын нэрт Монголч эрдэмтэн Валтер Хайссиг. Тэрбээр "Монголын шашин суртахуун", "Монголын уран зохиол" зэрэг бүтээлдээ "... XVII-XVIII зууны үеийн шарын шашны зүтгэлтнүүд, тэр дундаа Мэргэн гэгээн Лувсандамбийжанцан монголын аж ахуй амьдралын элдэв зан үйлд зориулан ерөөл, магтаал, сургаал, залбирал зэрэг олон шад шүлэг найраг зохиосон хийгээд бөөгийн тэнгэрт зориулсан ерөөл, залбирал, онгод сахиусыг ламын шашны онол журамтай уялдуулан нэгтгэсэн юм.²" гэж түүний монгол уншлагын талаар ихэд сонирхолтой ажиглалт хийж, Мэргэн гэгээний зохиол бүтээлийн агуулга, үзэл санааны онцлог шинж, Монголын соёлын түүхэнд үзүүлсэн гавъяа зүтгэл зэрэг олон талаар нарийвчлан судлаад өөрийн дүгнэлтээ хийсэн байдаг.

1998 онд Мэргэн гэгээн судлалын ажлын хэсгийнхний нөр их хөдөлмөр, хүчин чармайлтын хүчээр нэн ялангуяа Мэргэн хийдийн Цорж багш Ишпрэнлэйжамц (Мөнхбат) Өвөр монголын багшийн их сургуулийн профессор Ү.Наранбат, Мэргэн хийдийн баруун Да багш Жамъян, цогчин унзад Лувсансэнгэ, эрдэмтэн Б.Мөнх нарын зүтгэлээр "Очирдарь мэргэн даяанч ламын гэгээний бум зарлиг хэмээгдэх оршвой" нэртэй 5 боть судрыг хурал номын аяын сонгомол буюу хурлын уншлагын ая данг хөгжмийн нотоор тэмдэглэн хэвлүүлсэн байдагаас гадна, Мэргэн хийдийн хурлыг бодитоор нь шингээн авч, хуурцагт бичин, нийт зургаан боть болгон нийтэлсэн байна. Энэ бол монгол уншлагын үнэ цэнтэй сурвалж болж чадсан хийгээд монгол номыг дэлгэрүүлэхэд цаглашгүй их ач буянтай үйл болсныг энэ ялдамд дурьдах учиртай. Бурханы шашны түүх, зан үйл, улмаар хэл шинжлэлийн судалгаанд монгол уншлага тодорхой ач холбогдолтой гэж бид үзэж байна.

Судалгааг явуулахдаа түүхэн аргагүйг удирдлага болгон, асуудалд аль болохуйц бодитой, тодорхой хандах зарчим баримталсан болно. Судлагдахуун асуудлыг түүхэн тодорхой орон, цаг, нөхцөл байдалд нь судлан авч үзэж, залгамж холбоо, сэтгэлгээний хөгжлийн тухайн төвшинд холбон судлахыг эрмэлзлээ. Асуудалд бодитой хандах үүднээс аль болох эх хэрэглэгдэхүүн болсон монгол уншлагын судруудад түшиглэсэн. Ингэхдээ тухайн судруудын орчуулгын хувилбаруудыг харьцуулах оролдлого хийсэн болно. Түүний сацуу монгол уншлага бий болсон түүхэн шаардлагыг тухайн цаг үеийн оюуны хэрэгцээ шаардлага, тэдгээрийн дотоод, гадаад хүчин зүйлстэй нь хамтатган авч үзэж, басхүү уламжлалт хэвшсэн хэлбэр бий болох түүхэн шаардлагыг гаргаж ирэхийг хичээсэн.

Судалгааны аргын хувьд философи, шашин судлалын түүхийн шинжлэх ухаан, эх бичиг судлалын уламжлалт задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, сэтгэлгээний уламжлалын дотоод хийгээд гадаад хүчин зүйлсийг харьцуулах, жиших, дүгнэх аргыг гол болгосон бөгөөд мөн буддын уламжлалт тайлбарлалын аргыг түшиглэсэн болно.

Тус судалгаа: Монгол уншлагын эх судрууд, гар бичмэлүүдэд суурилав. Мөн монгол уншлага түүний түүхтэй холбогдол бүхий судалгааны зохиол бүтээлүүд болсон. Д.Цэрэнсодномын "ХИҮ зууны үеийн яруу найрагч Чойжи-Одсэр", Г.Галлуу, Жарантай

¹ П.Б.Балданжапов. Алтан товчи монгольская летопись XVIII., Улан-үдэ., 1970
² W. Heissig, Geschichte der mongolischen Literatur, Band-I, Wiesbaden, 1972. 143

нарын “Мэргэн гэгээн Лувсандамбийжанцаны бум зарлиг хэмээгдэх оршвой”, Ү.Наранбат, Б.Мөнх “Мэргэн гэгээн судлалын өгүүллүүд”, В.Хайсиг “Монголын шашин суртахуун”, “Очирдарь мэргэн гэгээний бум зарлиг оршвой” зэрэг бүтээлүүд эрдэм шинжилгээний чухал хэрэглэгдэхүүн болсон юм.

Түүнчлэн А.Позднеев, В.Хайсиг, И.Майский, Н.Поппе, Ц.Дамдинсүрэн, Н.Сайшаалт, Б.Насан, Э.Хурцбилэг, Ц.Энх нарын судалгаа бидний ажилд чухал ач холбогдол бүхий байсныг онцлон тэмдэглэе.

Ардчилал эргэлт буцалтгүй болсон өнөө үед шашин шүтэх, эс шүтэх нь тухайн хүний эрх чөлөөний асуудал болсон. Монгол улсын Үндсэн хуульд үүнийг заасан тогтоол байдаг. Хүн ардын дунд шашин шүтэх үзэгдэл түгээмэл байна гэдгийг судалгаа харуулж байна¹. Хүмүүс тодорхой ойлголттой болж, танин мэдсэн учраас тухайн шашныг шүтэж байна уу, эсвэл даган дуурайж, сохроор (догматикаар) шүтэж байна уу гэдэг асуудал ер нь өргөн далайцтай судалгаа шаарддаг.

Шашныг сохроор шүтэн бишрэх нь тухайн хүний оюун ухааны үнэт чанарыг алдагдуулдаг, цаад утгаараа танин мэдэхүй рүү биш харин мунхрал руу хөтөлдөг.

Бидний олон үеийн турш шүтэн биширч ирсэн Бурхан шашин нь юу юуг номлож, юу сургаж байгаа хийгээд дотоод мөн чанар нь ямар утга учир бүхий байдаг болохыг манай ард түмэн ухаан ойлгож, тийм ч учраас өнөөг хүртэл уламжлан хүндэлж дээдэлсээр ирсэн. Харин шашин шүтлэгийн эрх чөлөөний тухай тууштай ярих болсон чөлөөт сэтгэлгээний энэ үед цаг үе өөрөө энэхүү аугаа номлол, сургаалыг төрөлх хэлээрээ явуулахыг биднээс шаардаж байна

Бурхан багшийн сургаал нь дорно дахины ард түмний билиг оюуны сан хөмрөг, мэдлэг ухааны охь шим, ертөнцийг үзэх үзэл, гүн ухааны сэтгэлгээний томоохон ололт юм.

XXI зууны хүн төрөлхтний хөгжлийн чиг хандлага өнөөдөр өөрчлөгдөхөд хүрээд байна. Тус зуунд эрчимтэй хөгжиж байсан техник технологийн дэвшил нь мухардмал байдалд хүрч, цаашид энэ хурдаараа үргэлжлэх аваас хүн төрөлхтөн өөрсдийгөө мөхөлд хүргэхийг өдгөө дэлхий дахинаараа ухаарч байна. Тиймээс XXI зуун бол оюуны зуун буюу хүн рүү чиглэсэн “гэхдээ хүний бие махбодыг биш” харин жинхэнэ хүн гэдгийг илэрхийлдэг цорын ганц атрибут шинж болох оюун ухааныг судлах, түүний нууцад нэвтрэхэд чиглэгдэж байна. Үүнийгээ дагаад энэ шинэ зуун бол хүний дотоод сэтгэл рүү өнгөрсөн, ухаарал бясалгалын буюу өөрөөр хэлбэл хүний оюун ухааныг хөгжүүлэх зуун болох хандлага ажиглагдаж байна. Ийм учраас Бурхан багшийн гүн нарийн учир шалтгаантай, шинжлэх ухаанч, зүй зохистой, оюун ухааны охь шим болсон үнэний сургаал нь улам бүр үнэ цэнэтэй болохын зэрэгцээ түүнийг эх хэлээрээ сонгох нь монгол хүний хувьд чухалтай болж байна.

Бурханы шашныг шүтэх түүний туйлын мөн чанарт хүрнэ гэдэг бол Буддын шашны ёс, хурал ном, гүрэм заслыг ам дагуулан уншихыг голлохоосоо сургаал номлолын мөн чанарыг ухаарч чадваас ямарч бүтээл ид шидийг олж чаддаг байна. Бурханы шашны номыг эх хэлээрээ урин залж, учир шалтгааныг ухаарч, авах гээхийн ухаанаар хандах нь орчин цагийн нэн чухал шаардлага юм.

Монголоор уншаад номын хүч хүрдэггүй, адистэдгүй гэж зарим хүмүүс хэлэх нь бий. Тийм эсэхийг туршлагаар, судалгаагаар, шинжлэх ухааны үндэслэлтэйгээр нотлох хэрэгтэй. Мөн Монгол оронд шашныг дэлгэрүүлэгч найман их хүний нэг Нэйж тойн-Авида хутагт бээр “...Эртний Энэтхэгийн шашин Төвд дор ихэд дэлгэрсэн ба Төвдөөс


¹ С.Цэдэндамба. Монгол Улс дахь шашины нөхцөл байдал, УБ, 2003. 34 дэх тал

урьд зарим Монголд бурханы шашин дэлгэрсэн боловч өөрийн хэлээр бус дэлгэрүүлбээс тэр нь санах бясалгахад хялбар бус, доор оюунтан юуг бээр ч мэдэх үгүй, эс мэдсэнээр сүсэг бишрэл хийгээд ухаан төрөхөд бэрх”¹ хэмээсэн нь Монголд Төвдөөс өмнө бурханы шашин дэлгэрсэн тухай дурьдаад, төрөлх хэлээр бус харь хэлээр номыг дэлгэрүүлэх нь номын утгыг мэдэхэд бэрх, үл мэдсэнээр сүсэг хийгээд онолын эрдэм үл төрөх, харин өөрийн хэлээр уншваас утгыг хялбар олон мэдэж, уншсан төдийхнөөр сүсэг төрөн, давтан уншсанаар онолын эрдэм төрөхөд саад үгүй тухай хэлсэн байна.


Хүн бүрт илтэд туулсан бурханы мөн чанар оршин байдаг хэмээн бурхад айлддаг бөгөөд бурханыг гаднаас бус зөвхөн өөрийн дотоод сэтгэлээс эрж хайх хэрэгтэйг буддын гүн ухааны судар номуудад олонтоо дурьдан номлодог. Хүнд бурхан бодьсатва нарын нэгэн адил далдыг мэдрэх, рид үзүүлэх чадварлаг оюун ухаан билгүүн заяагдсан байдаг ба энэ нь далд нууц “элдэв гэм нүглээр бүрхэгдэн” орших агаад тэрхүү нууц далд хүчээ илрүүлэн гаргах (гэгээрэх) бүрэн бололцоотой гээд үүнийг нээн илрүүлэх гагц арга зам бол бясалгал гэдэг.

Бясалгал нь хүн өөрийн оюун бодлоо маш нарийн дэс дараатай олон үе шатыг дамжин, ийш тийш гуйвуулан сарниулалгүй, гадна орчны элдэв нөлөөнд сэтгэлээ хоёрдуулалгүй, номын ёсоор тогтвортой, нэгэн зүг төвлөрүүлэн гүнзгийрүүлэх сэтгэхүйн нарийн үйл явц юм. Үүнээс үзвэл бясалгал нь сэтгэхүйн үйл явц юм бол “хүний сэтгэхүй, хэл яриатай нягт холбоотой байдаг”² тул бясалгал үйлдэхэд хэл нь сэтгэхүйд шууд нөлөөлөх учиртай. Тухайлбал, тухайн (бурхадын дүр хөрөг, эрдэм увидас зэрэг) судрыг унших явцад тэнд үгүүлэгдэх ёсоор сэтгэхүйд шууд тусч, тухайн үгүүлэмжийн хүчээр бясалгал зөв явагдах дүрэмтэй байна. Эх хэлээрээ ном уншин бясалгавал “номын хүч” олоход дөхөмтэй.

Шинжлэх ухааны сүүлийн нээлтүүдээр хүний энергийг судалж зарим нэг сонирхолтой үр дүнд хүрч байна. Үүний нэг бол Японы эрдэмтэн Масару Эмотогийн нээсэн усны талст хүнээс гарч байгаа эерэг сөрөг эрчим хүчийг хэрхэн хүлээн авч молекул төвшинд хүрч үйлчлэн, талст нь өөрчлөдөг болохыг нотолсон судалгаа юм. Хамгийн олзуурхууштай нь ямар нэг шилэн саванд ус хийгээд түүнд хандан сайн муу үг хэлэхэд яг тэр хэлж байгаа үгний агуулгаар, жишээ нь “хайр талархал, баярлалаа, аз жаргал” гэх мэт сайн сайхан үг хэлэхэд усны талст зөв хэлбэртэй, хүрдэн юм уу бурхадын хот мандал шиг хэлбэртэй, талст нь гоёмсог болох бөгөөд олон янзын хэлээр “баярлалаа” гэдэг үгийг бичиж харуулахад дандаа бүрэн бүтэн үзэсгэлэнтэй гоё талст үүсдэг³ байна.



Хайр хийгээд талархал



Баярлалаа (Япон хэлээр)


¹ “Чандмань эрхийн судлал” Б.Мөнх., СХХ., 1995. 75-ртал

² “Философийн толь” 1990.388-р тал

³ Масару Эмото “Хариулт нь усанд буй” УБ.2007. 6-р тал

Сайн сайхан үгний хэлбэлзэл дэлхий ертөнцөд эерэг нөлөөтэй байдаг бол сөрөг утгатай үгийн хэлбэлзэл устгах хүчтэй ажээ.¹

Тухайлбал: “ална шүү, чи муухай, үхэл, чөтгөр” гэх зэрэг сэтгэлд таагүй муу үг харуулахад хэлбэр дүрс эвдэрч, тэгш бус арзгар болж өөрчлөгддөг байна. Тэр хүн япон хэлээрээ л хэлж байсан бөгөөд хожим оросын эрдэмтэд уг туршилтыг баталсан байдаг. “Чөтгөр” гэдэг үгийг хэлэхэд дайрахад бэлэн байгаа мэт голдоо бөөн бараан нягтралтай талст гэхээргүй дүрс үүсчээ.



Чөтгөр (Японоор)

Бурханы номын уншлагын судар нь сайн сайхныг урин дуудсан агуулгатай байдаг бөгөөд бурханы шашны хурал номын уншлага уншсан усны талст нарийн давхарлан тогтсон буддын сүм дугантай адил хүч чадлыг илтгэдэг байна.

Бурханы шашны ширнэн буюу билгийн зүрхэн сударт “Дүрс бүхэн хоосон, хоосон ч дүрс мөн, дүрс лүгээ хоосон ялгал үгүй болой”² хэмээх бурхан багшийн хачирхам зөрчилтэй үг үнэн болохыг орчин үеийн шинжлэх ухаан улам бүр баталж байгаа нь нэн гайхамшигтай.

Хүний биеийн 70% нь уснаас бүтдэг учир хараал болоод ерөөл гэдэг нь хүмүүн бидэнд сайн муугаар нөлөөлсөөр ирсэн бөгөөд “үгийн ид шид” гэдэг ийм учиртай байж ч болох юм. Чухам энэ хууль үйлчилдэг учраас л дом шившлэг бидний тайлбарлаж чаддаггүй хүчээр нөлөөлж чаддаг болов уу гэж үзэж болмоор байна.

Эндээс үзэхэд хүнд өөрт нь асар их эрч хүч, энерги агуулагдаж байдаг нь харагдаж байгаа бөгөөд тэр нь үгээр дамжин илэрч гадна ертөнцөд шууд нөлөө үзүүлдэг байж болно. Судар тарнийг олон дахин давтан уншиж, бясалгал даяан хийснээр номын хүч, ид шид, адистэд оршин, тухайн тарни номыг уншсан төдийгөөр ямар ч их бүтээлийг хийж болох тухай ойлголт байдаг. Энэхүү ойлголтонд бид эдүгээ шинжлэх ухааны байр сууринаас хандах хэрэгтэй юм.

Монгол уншлагын судалгаа бол зөвхөн Бурханы шашны ном судрыг орчуулаад унших төдий асуудал биш. Энэ нь гүн ухаан, анагаах ухаан, шашин номын зан үйл зэрэг олон салбар ухааныг хөгжүүлж ирсэн үүх түүх, монгол уншлагыг дагалдан Бурханы шашны их бага арван ухаан Монголд хөгжиж дэлгэрсэн зам мөр, тэдгээр ухааны утга агуулгыг ойлгоно гэсэн үг болно.

Монгол уншлагыг дэлгүүлсний өөр нэг чухал онцлог нь Буддизмыг монгол төрх, утга агуулгатай болгон, бурханы шашин бол монголын буддизм, монголын үндэсний шашин мөн хэмээн хэлэх үндэстэй болж ирнэ.

¹ Мөн тэнд „УБ.2007. 24-р тал

² “Билэг бараамид” судар оршвой. Хувийн цуглуулгад., 7х28см., 7хуудас. гар бичмэл

Нэйж тойн хутагт, Мэргэн гэгээн тэргүүтэн мэргэдийн монголоор ном дэлгэрүүлэхийн төлөө хатуу бэрхийг туулан, цөхрөн зовж явсны цаад зорилго нь монголын буддизмыг буй болгохыг хичээж байсанд оршино. Энэ тухайд В.Хайсигийн "XVIII зууны үед олон сургаалыг нийлүүлэн монгол шашныг буй болгохоор ихэд оролдож байсан... ламын үйлдлэг ихэд амжилтанд хүрчээ"¹ гэсэн дүгнэлт бэлхнээ батлан үгүүлж буй.

Харин бурханы шашин бол монголчуудын олон зуун жилийн турш шүтэн биширч ирсэн монгол үндэсний ахуй амьдрал, ёс заншил нэвт шингэсэн монголчуудын хуучин шүтлэг бишрэлийн ухагдахуун өөртөө багтаан оруулсан нэгэн ёсны өвөрмөц онцлогтой монголын Буддизм болон хөгжсөөр иржээ. Энд миний дээр өгүүлсэн монгол шүтлэгийг бурханы шашны ухагдахуунд оруулсан ихэнх судар нь монгол хэлээр монгол уншлагын жаяг дэгээр тархсан ба төвд ном сударт тэдгээр нь тэр бүр орчуулагдаагүй (Чингисийн сан төвдөөр үгүй) байдаг учраас төвд уншлагатай сүм хийдүүд нь энэ тал дээр ихээхэн учир дутагдалтай учир монгол Буддизмын нүүр царайг төдийлөн илэрхийлж чадаагүй байна.

Жирийн ард иргэд, сүсэгтнүүд маань бурханы шашин, түүний сургаал номлолыг сурч мэдэх, ухааж ойлгох наад захын хялбаршуулсан сурах бичиг, ном товхимол байхгүйн дээр бүгд төвд хэл дээр байдгаас, тэдэнд бурханы номыг сурч мэдэхэд нэн төвөг бэрхшээлтэй, хэрэв тэдгээр өглөгийн эзэд бурханы сургаалыг ойлгоё, мэдье гэж санахад эхэнд нь заавал төвд бичиг үсэг сурна дараагаар нь уншиж бичиж сурах, тэгээд нэр орчуулга үзнэ, тэгж байж сая шашин номын анхны мэдэц, ойлгоцтой болох бөгөөд харамсалтай нь энэ бүхнийг хийхэд ихээхэн цаг хугацаа шаардагддаг тул тэдэнд тийм их цаг зав олдохгүйн улмаас тээршаан хааяа нэг Гандан хийдүүдэд хийморийн сан, даллага уншуулах төдийгөөр тэдний бурханы шашны тухай ойлголт, түүнд хандах хандлага хязгаарлагдаж байна.

Хэрэв зарим нэг сүм хийдүүд өөрийн төрөлх хэлээрээ ном хурж байвал сүсэгтэн олон өглөгийн эзэд ном судрын талаар ойлголттой болж, түүнээ мухар сүсгээр бус ухамсартай сүсгээр шүтэх болж, ингэснээр сая номын ёсноо нийцэх буюу.

Мөн монгол уншлагын судар ном хэвлэгдэн олны хүртээл болсноор² сүсэгтэн олон маань өөрсдөө өдөр тутмын чухал хэрэгтэй сан тахилгын судруудаа уншин сүслэх боломжтой болох юм. Ийнхүү сүсэгтэн олон бие хэл сэтгэлээрээ сүслэн залбирснаар сүсэг төрнө, буян хурна, сахиус бурхан нь ч баясна цаашлаад ажил үйл нь бүтэх учиртай. Улмаар бурханы шашны утга учрыг ухаарсан үнэн чин сүсэгтэн болно. Үнэн сүсэгтэн олшрохын хэрээр бурхан шашин улам дэлгэрэх ач холбогдолтой юм.

Бурханы шашны монгол уншлагын түүхэн уламжлалыг тодруулан гаргах нь манай шашин судлалын түүхийн судалгаанд нэмэр хандив болох болов уу гэж санаж тус бэсрэг судалгааг хийсэн болно. Олон уеийн турш шүтэж биширсээр ирсэн, судалж сурсаар ирсэн шашин номоо бүрхэгдүүлэн орхиж, олон шашны хөлийн тоосонд дарагдуулах аваас монгол соёл бүрхэгдэх нэгэн шалтгаан болох магадлалтай.

Монголын ард түмний зан заншил, уламжлалт ёс, зан үйл, ахуй амьдрал, ертөнцийг үзэх үзэл бүхнийг бурханы шашин лугаа гүн барилдсан бөгөөд үүнийг бурхан шашнаас ангид авч үзэх юм бол усан дотроос хуурай чулуу хайхтай адил агаад бурханы шашнаа бид монгол ёсоор нь дэлгэрүүлж чадаж байж монголын соёл, үндэсний уламжлалаа авч үлдэх учиртай билээ.

¹ В.Хайсиг "Монгол шашин суртахуун" Хөх хот 1998.15-д үзэх

² Д.Ганбаатар "Бурханы номын монгол уншлагын судар. CD". УБ., 2010.

Ишлэл авсан бүтээлүүд

1. А.Амар "Монголын товч түүх" .,УБ 1989
2. Б.Батбаяр "XX зууны нүүдэл суудал" ., УБ 1996
3. П.Б.Балданжапов. "Алтан товчи монгольская летопись" XVIII. Улан-үдэ. 1970
4. Богд Зонхава "Бодь мөрийн зэрэг" .,УБ 2006
5. Buddhism in Mongolia ., Budapest.1981
6. "Буддын шашин, соёлын тайлбар толь" 1,2-р боть, Ш.Чоймаа, Л.Тэрбиш, Д.Бүрнээ, УБ 1999
7. Д.Ганбаатар "Бурханы номын монгол уншлагын судар" ., УБ 2010
8. А.М.Позднеев "Очерки быта Буддийских монастырей и Буддийского духовенства в Монголий в связи с отношениями сего последнего к народу" Улан- Удэ 2000 г
9. Louis Ligeti "Gatalogui du Kanjur mongol impire", Budapest.1942
10. Масару Эмото "Хариулт нь усанд буй" ., УБ.2007
11. "Мэргэн хийдийн уг түүх оршив" ред. Б.Мөнх ., СХХ 1948
12. Б.Мөнх "Мэргэн гэгээн Лувсандамбийжанцан" ., СХХ 1995
13. Ү.Наранбат Б.Мөнх "Мэргэн гэгээн судлалын өгүүлэлүүд" ., СХХ 1997
14. N.Poppe, "Ein monolisches Gedicht aus den Turfan Funden" .vol,5., 1960
15. Сүмбэ хамба Ишбалжир "Бурханы шашны түүх", АХХ 1993
16. В.Хайссиг "Монголын шашин суртахуун", АХХ 1998
17. W. Heissig, Geschichte der mongolischen Literatur, Band-I, Wiesbaden, 1972
18. Л.Хүрэлбаатар "Монгол орчуулгын товчоон", УБ 1995
19. Я.Цэвэл. "Монгол хэлний товч тайлбар толь", УБ 1966
20. Д.Цэрэнсодном "Монголын бурханы шашны уран зохиол", УБ 1997
21. Д.Цэрэнсодном "14-р зууны үеийн яруу найрагч, Чойжи-Одсэр", УБ 1969

Abstract

Judging from the scientist survey, Buddhism theology passed for over 2000 years in Mongolia. It is one of the most important issues of Buddhism in Mongolia from when Mongolians read to acquaint with theology and was ministering a meeting by Mongolian language their theology.

Buddhism theology is translated into native language by our ancestors and gradually became recitation of meeting religious chant as well as we are continuing without dissecting their tradition. We are considered that theology certainly necessary to hold meeting by Mongolian language in nowadays, which became free in terms of religion book, citizens have right of denomination and non denomination, select to meditate from many religions and abandon to doctrine.

Therefore, owing to we are necessary to study our Mongolian recitation, which is forgotten at the seams at present and we need to emphasize this activity, which will reconstitute our Mongolia recitation that has ancient tradition and briefly introduce from procedures of Mongolia recitation for faithful and zestfully researchers. In addition to we consider that need to develop and find a properly attitude of tradition conversion in compliance with modern exigency our Mongolian recitation.